

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.01.21-01.25

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн 2 индекс өсөлттэй, 1 индекс бууралттай хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтаж буй мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдсан бол өргөн хэрэглээний болон эрүүл мэндийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

Долоо хоногийн эхээр дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч байгааг илтгэж буй үзүүлэлтүүд гарч, хөрөнгийн зах зээлийн индексүүд буурчээ. Олон улсын валютын сан 2019 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн таамгаа 3.7%-аас 3.5% болгон бууруулав.

АНУ, БНХАУ худалдааны асуудлаар Бээжин хотноо дунд түвшний хэлэлцээ хийснээс хойш АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп хөрөнгө оруулагчдыг тайвшруулж, хоёр талын худалдааны хэлэлцээр байгуулахад томоохон ахиц гарч байгаа гэж мэдэгдэж ирсэн юм. Эх сурвалжийн мэдээлснээр талуудын хэлэлцээнд маш бага ахиц гарсан төдийгүй АНУ, БНХАУ-тай хэлэлцээр байгуулсан ч учир дутагдалтай байхыг үгүйсгэхгүй гэж таамаглажээ.

АНУ-ын Сенат Пүрэв гарагт тав дахь долоо хоногтоо үргэлжилж байгаа Засгийн газрын саатлыг зогсоох хоёр ч төсвийн төсөлд санал хураалт явуулахаар төлөвлөжээ. Тухайлбал, нэгт нь хана барихад шаардлагатай 5.7 тэрбум ам.долларын санхүүжилтийг багтаасан бол нөгөө нь Ардчилсан намын санаачилгын дагуу хоёрдугаар сарын наймныг хүртэл Засгийн газрын үйл ажиллагааг сэргээх, энэ хугацаанд хилийн аюулгүй байдлыг хангах асуудлаар хэлэлцэх санал багтжээ. Ингэснээр хөрөнгийн зах зээлд эерэг хандлага үүсч, голлох индексүүд өссөн байна.

Энэ долоо хоногт хувьцаат компаниудын 2018 оны 4-р улирлын тайлангууд гарчээ. S&P 500 индексийн сагсанд багтдаг хувьцаат компаниудын нийт ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.9%-аар өссөн талаар "FactSet" агентлаг мэдээлэв.

Европ: 12-р сараас эхлэн Европын бүсийн эдийн засаг саарч байгаа талаар Европын Төв банкны тэргүүн ноён Марио Драги мэдээллээ. Мөн Европын Төв банк тус бүс нутгийг эдийн засгийн хямралаас гаргах зорилгоор мөнгөний бодлогоо зөөлрүүлж магадгүй байгаа ажээ.

1-р сард Герман улсын аж үйлдвэрийн салбарын үзүүлэлт буурч эхэлсэн нь Европын бүс нутгийн эдийн засаг саарч байгааг илтгэх бас нэгэн үзүүлэлт болжээ. Германы худалдан авагч менежерүүдийн индекс 1-р сард сүүлийн 4 жилийн доод түвшинд буюу 49.9 нэгжид хүрсэн талаар "IHS Markit" байгууллага мэдээлэв.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс өсөлттэй хаагдлаа.

Японы төв банкны Мөнгөний бодлогын зөвлөл энэ сарын 22-23-ны өдрүүдэд хуралдаж мөнгөний бодлогондоо өөрчлөлт оруулахгүй байхаар шийдвэрлэв. Тус байгууллага 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөжийг 0.0%, богино хугацаат бодлогын хүүг -0.1%-д барин, жилд 80 их наяд иенийн бондыг худалдан авах бодлогоо хэвээр үлдээлээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,379.66	-1.03% ▼
Dow Jones	АНУ	24,737.20	0.12% ▲
S&P 500	АНУ	2,664.76	-0.22% ▼
Nasdaq	АНУ	7,164.86	0.11% ▲
S&P/TSX	Канад	15,366.05	0.41% ▲
FTSE 100	Их Британи	6,809.22	-2.28% ▼
S&P/ASX 200	Австрали	5,905.60	0.44% ▲
Nikkei 225	Япон	20,773.56	0.52% ▲
Hang Seng	Хонг Конг	27,569.19	1.77% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	109.92
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	98.69
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	97.73
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.23
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.80
DBM' 2023	USD	7.250%	100.79
TDBM' 2020	USD	9.375%	104.46

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.500	-0.01 ▼
Libor 3M	2.750	-0.01 ▼
Libor 6M	2.830	-0.02 ▼
Libor 1YR	3.031	0.00 ▲
US 2YR Bond	2.602	-0.01 ▼
US 3YR Bond	2.580	-0.02 ▼
US 5YR Bond	2.589	-0.03 ▼
US 10YR Bond	2.750	-0.03 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.01.25	Өөрчлөлт
USD	2,632.72	-0.67% ▼
CNY	389.26	-0.53% ▼
EUR	2,981.69	-1.24% ▼
RUB	39.88	-0.13% ▼
KRW	2.35	-0.42% ▼
JPY	23.98	-1.07% ▼
CAD	1,977.41	-1.03% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,302.93	1.59% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	15.80	3.20% ▲
Зэс	USD/lb.	271.75	0.57% ▲
Нүүрс	USD/MT	99.30	-1.68% ▼
WTI газрын тос	USD/bbl.	53.36	-1.19% ▼
Brent газрын тос	USD/bbl.	61.37	-2.48% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.93	-12.54% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. XII	8.10%
Бодлогын хүү	2018. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XI	10.20%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	12.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XI	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XI	17.30%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XI	10.70%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 43 компанийн 1,150.1 сая төгрөгийн 3,496,864 ширхэг хувьцаа арилжигдав.


“Увс чацаргана” /CHR/ компанийн хувьцаа 28.57%-аар буюу хамгийн ихээр өсч 450 төгрөгт хүрч хаагдсан бол “Цагаантолгой” /TSA/ компанийн хувьцаа 14.99%-аар буурч 2,360 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 33 ширхэг үнэт цаас 3.3 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.


1-р сарын 25-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,468.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,379.66 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.03%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,153.4
Зах зээлийн үнэлгээ	2,467,972.2

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,379.66	-1.03% ▼
MSE I индекс	9,880.39	-1.02% ▼
MSE II индекс	8,671.03	-0.81% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	1,320,860	803,602,832
ЛэндМН ББСБ	1,664,933	110,421,747
Говь	187,057	61,579,474
Мандал даатгал	8,679	44,050,831
Ард даатгал	43,128	30,874,381

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Увс чацаргана	450.00	28.57% ▲
Тав	12,070.00	14.95% ▲
Багануур	1,500.00	13.04% ▲
Стандарт агрикалчер групп	300.00	11.11% ▲
Гермес центр	150.00	7.14% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Цагаантолгой	2,360.00	-14.99% ▼
Ремикон	26.50	-11.67% ▼
Монголын цахилгаан холбоо	440.00	-10.55% ▼
Монгол базальт	270.00	-9.40% ▼
Дархан зочид буудал	89.49	-8.68% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Бумбат-Алтай	1,503,829,799
Би Ди Сек	166,969,619
Мирэ Эссет Секьюритис Монгол	107,640,569
Голомт Капитал	97,767,464
Ард секьюритиз	78,691,426

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	610.00	649,151
Таван толгой	7,095.00	373,660
МИК	14,750.00	305,462
Говь	330.52	257,843
Сүү	200.34	68,917

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-11/04/19-A0230-18	13	1,300,000	100,000	100,000	104	18.000%
2	ZGEB-BD-24/10/19-A0348-13.955	20	2,000,000	100,000	100,000	104	13.955%

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Шинэ ХК-иуд 2018 оны ашгаасаа хувьцаа эзэмшигчдэдээ олгоно

IPO хийж олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөө үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд ашигласан компаниуд ногдол ашиг тараана гэдгээ мэдэгдээд байна.

IPO хийснийхээ үр өгөөжийг нь хүртэж байгаа учраас хувьцаа эзэмшигчдэдээ 2018 оны ашгийн тодорхой хувиа өгөх нь зөв гэж "Айтүүлс", "ЛэндМН" компаниудын удирдлагууд үзэж байгаа ажээ. Хувьцаат компаниудын санхүүгийн тайлан эцсийн байдлаар аудитаар баталгаажсаны дараа ашгийн хэдэн хувийг ногдол ашиг болгон тараахаа хурлаар шийдвэрлэх юм байна.

"Айтүүлс" компанийн хувьд 2017 оны 11 дүгээр сард IPO хийж, олон нийтээс 1.3 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн юм. Үүний дараа хувьцааны ханш нь хоёр долоо хоногийн хугацаанд 2.5 дахин өсч, 250 төгрөгт хүрч байв. Тус компани 1-р сарын 25-нд санхүүгийн тайлангаа олон нийтэд танилцуулах ажээ.

Харин "ЛэндМН" компани 2018 оны 3-р сард IPO хийж, таван тэрбум төгрөгийн санхүүжилт татсан юм. Урьдчилсан байдлаар тус компани 2018 онд 2.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан тооцоо гарч байгаагаа мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

"Топ 20" индексээс хасагдсан "Адуунчулуун" ХК-ийн хувьцааны ханш 2018 онд 32.3 хувиар унажээ

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Топ 20" компанийг жил бүр шинэчлэн гаргадаг билээ. Энэ удаад "Адуунчулуун", "Шарын гол", "Шивээ овоо" зэрэг уул уурхайн гурван компанийг "Топ 20" индексээс хассан байна. 2018 онд эдгээр компаниудын хувьцааны арилжааны идэвх буурч, нэгж хувьцааны ханш унаснаар зах зээлийн үнэлгээ нь буурчээ.

Ингэснээр "Топ 20"-ийн жагсаалтаас хасагдахад хүрсэн байна. Эрчим хүчний станцуудад нүүрс нийлүүлдэг компаниуд олон жил алдагдалтай ажиллаж байгааг "Шивээ овоо" компанийн Гүйцэтгэх захирал "Bloomberg"-д өгсөн ярилцлагынхаа үеэр онцолж байсан юм. Учир нь нүүрс олборлох зардал, борлуулж байгаа үнээс өндөр байдаг учраас тус компани тонн тутамд алдагдал хүлээж байгаа ажээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд олон жил ярьсан уурхайг түшиглэсэн томоохон цахилгаан станцын төслүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг дурдаж байв.

2018 онд "Адуунчулуун" компанийн хувьцааны ханш 32.3 хувь, харин "Шарын гол" компанийн хувьцааны ханш 19.1 хувиар тус тус буурсан байна. "Шарын гол" компани 1993 оноос хойш хувьцаа эзэмшигчдэдээ хоёр удаа ногдол ашгаа тарааж байсан юм. Мөн "Шивээ овоо" компани ижил хугацаанд хөрөнгө оруулагчдадаа гурван удаа цэвэр ашгаасаа тодорхой хувийг хуваарилж байсан гэж Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ. Энэ онд "Топ 20" индексийн сагсанд уул уурхайн салбарын компаниудаас зөвхөн "Тавантолгой" ХК л багтаж байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

СЗХ-оос үнэт цаасны зарим компанийн үйл ажиллагааг хязгаарлажээ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо 2016 онд 94 тоот тогтоол баталж, үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх бол 30.0 сая төгрөг, үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх бол 100.0 сая төгрөг, дилер хийх бол 200.0 сая төгрөг, андеррайтер 1.0 тэрбум төгрөг байхаар хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг тогтоосон. Тогтоолыг 2017 оны 1-р сарын 01-нээс мөрдөж эхэлсэн боловч зарим нэр бүхий үнэт цаасны компани одоог хүртэл хувь нийлүүлсэн хөрөнгөө зохих хэмжээнд хүргэхгүй, зах зээлийн зуучлалын үүргээ хэрэгжүүлэхгүй, Хорооноос тавьж байгаа шаардлага, шалгуурыг хангаж ажиллахгүй байна. Иймд Хороо шаардлага хангахгүй байгаа компаниудын зах зээлд оролцох оролцоонд хязгаарлалт тавьж байгаагаа албан ёсоор мэдэгдэж байна.

Бизнесийн үйл ажиллагаа, зах зээлд оролцох оролцоог хязгаарласаар байхад цаашид Хорооноос мөрдүүлж буй шаардлага, шалгуур, зохистой харьцааг хангахгүй бол хууль тогтоомжийн дагуу шат дараалсан арга хэмжээ авахыг анхааруулж байна.

Хязгаарлалтад хамаарсан компаниас үнэт цаасны андеррайтер, брокер, дилерийн үйлчилгээ авах нь эрсдэлтэй болохыг хөрөнгө оруулагч иргэн, бизнесийн байгууллага, аж ахуй нэгжүүд анхаарч, үйлчилгээ үзүүлэгч компанийхаа санхүүгийн болон үйл ажиллагааны үзүүлэлтийг сайтар нягтлах, хязгаарлалттай холбоотой мэдээллээр Хороо болон бусад албан ёсны эх сурвалжид хандахыг зөвлөж байна.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Гадаадын биржид бүртгэлтэй компаниудад давхар бүртгэлийн талаар танилцуулга хийлээ

2018 онд үнэт цаасыг давхар бүртгэх хууль эрхзүйн орчин бүрэн бүрдэж, үүний дагуу МХБ нь 2018 оны 6-р сард хамгийн анхны давхар бүртгэлийн үнэт цаас буюу Канад улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ ресурс девелопмент корпорейшний хувьцааг бүртгэж арилжаалсан билээ.

Гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын хувьд үнэт цаасаа олон нийтэд нээлттэй гаргаж арилжаалах нь ард иргэдтэй төслийн үр ашгийг хуваалцах, олон нийтийн дунд компанийн үйл ажиллагааны талаарх ойлголт дэмжлэгийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой болох нь эхний давхар бүртгэгдсэн компанийн жишээнээс харагдаж байгаа хэмээн МХБ үзлээ. Иймд бусад уул уурхайн компаниудад энэхүү боломж, ач холбогдлын талаар танилцуулах үүднээс "Үнэт цаас давхар бүртгүүлэх боломж, анхны давхар бүртгэгдсэн компанийн туршлагаас хуваалцах семинар"-ыг МХБ-ээс 1-р сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

2018 онд хүчин чадал сайтай баяжуулах үйлдвэрүүд ашиглалтад оржээ

Монголын уул уурхайн салбарт нэг үеэ бодвол гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын төслүүд сэргэж, цөөнгүй үйлдвэр уурхайн үйл ажиллагаа эхлээд байна.

Баяжуулах үйлдвэрүүдийн хувьд “Монголын алт” компани өнгөрсөн долдугаар сард Гурвантэс суманд орших Нарийнсухайтын уурхайд Монголын анхны хүнд орчны модулийн Нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулсан юм. Монгол Улс дахь баяжуулахын томоохон үйлдвэрүүдийн төслүүдийн нэгд тус үйлдвэр тооцогдож байна. Нарийнсухайтын уурхайгаас жилд 5-6 сая тонн нүүрс олборлон экспортлодог. Тус компанийн мэргэжилтнүүд борлуулалтын нүүрсний чанарыг сайжруулах, нүүрсийг боловсруулах чиглэлээр туршилт судалгаа, эрэл хайгуулын ажлуудыг эрчимтэй явуулж ирсний дүнд орчин үеийн технологитой, жилд 1 сая тонн нүүрс баяжуулах хүчин чадалтай модулийн үйлдвэрийг ашиглалтад орууллаа. Энэ нь цаашид Нарийнсухайтын уурхайд баригдах томоохон хүчин чадалтай баяжуулах үйлдвэрийн технологийг сонгох үндэс болсон тухай “Монголын алт” компанийн мэргэжилтнүүд онцолж байна.

БНХАУ-ын Beijing Guobua Technology Group (BGTG) зураг төслийг боловсруулж, технологи, үндсэн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн ба мөн улсын Jiangsu Yangzhou Hengyuan Co.Ltd компани барилга угсралтын ажлыг гүйцэтгэж үйлдвэрийг сарын хугацаанд барьж ашиглалтад оруулсан юм.

2018 оны хувьд Дорнод аймгийн Халх гол сумын нутагт “Зэст Өндөр” компани 41 сая ам.доллар болон нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай төмрийн хүдрийн Уулын баяжуулах үйлдвэр (УБҮ), Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт Хятадын хөрөнгө оруулалттай “Тайшен Девелопмент” компанийн 70 сая ам.долларын хөрөнгө оруулалттай төмрийн хүдрийн уурхайн төслийн үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн. Тэгвэл Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлснээр 2018 онд 31 уурхай, баяжуулах үйлдвэр шинээр ашиглалтад оржээ.

Дашрамд дурдахад, баяжуулалтын салбарын хувьд Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын Боловсруулах салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд хоёр чухал баримт бичиг болох “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”, “Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг боловсруулах, шинэчлэн сайжруулахаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа юм. Ингэснээр шинээр ашиглалтад орох баяжуулах үйлдвэрүүдэд тавигдах шаардлагууд ойлгомжтой, хэрэгжүүлэхэд дөхөмтэй болох юм.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com



БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний импорт буурах төлөвтэй байна гэж “Wood Mackenzie” таамаглалаа

БНХАУ-ын эрчим хүчний нүүрсний импорт 2019 онд өнгөрсөн жилийнхээс зургаан сая тонноор буурч, 186 сая тонн болж магадгүй гэж “Wood Mackenzie” таамаглаж байна. Тус улсын Засгийн газар нүүрсний олборлолт, импортод тавих хяналтаа үргэлжлүүлэн чангатгах төлөвтэй гэдгийг онцолсон байна. Тодорхойгүй нөхцөл байдлын улмаас 2019 онд эрчим хүчний нүүрсний ханш нэлээд савлана гэж таамаглажээ. Мөн нүүрсний уурхайд дахин осол гарсантай холбоотойгоор БНХАУ-ын эрх баригчид уурхайнуудад тавих аюулгүй ажиллагааны стандартаа чангатгаснаар зарим уурхайг хааж, нийт гарцад нөлөөлж магадгүй гэж үзэж байгаа аж. Энэтхэг болон Зүүн Өмнөд Азийн орнуудын эрэлтээс хамаарч далайгаар тээвэрлэж байгаа нүүрсний эрэлт өсөх төлөвтэй байна. Хэдий тийм боловч энэ нь БНХАУ, Европын зах зээл саарсан, мөн Япон, БНСУ, Тайванийн эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа энэ орон зайг нөхөхүйц байж чадахгүй гэж “Wood Mackenzie” таамаглалаа.

Мөн гангийн үйлдвэрүүдийн ашиг буурах төлөвтэй байгаагаас шалтгаалаад металлургийн нүүрсний ханш төдийлөн хэлбэлзэхгүй гэж харж байна. Ханш харьцангуй тогтвортой байх нь БНХАУ-ын нүүрсний компаниуд хүчин чадлаа хязгаарлаж байгаа энэ үед тэдэнд ашигтайгаар тусна гэж тооцоолж байгаа аж. Нийлүүлэгчдийн зүгээс 2019 онд далайгаар тээвэрлэх нүүрсний экспортоо 20 сая тонноор нэмэгдүүлэхийг зорьж байгаа гэдгийг дурджээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



2019 онд үйл ажиллагаагаа эхлэхээр шохойн чулууны 7 төсөл ТЭЗҮ батлуулжээ

2019 онд шохойн чулууны долоон орд газар олборлолтоо эхлэхээр уулын ажлын төлөвлөгөөгөө батлуулсан талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ. Үүнээс хоёр нь Төв аймаг, хоёр нь Ховд аймгийн нутагт байрлаж байна.

Томоохон ордуудаас дурдвал Төв аймгийн нутагт байрлах цагаан шохойны ордын нийт хөрөнгө оруулалт дөрвөн тэрбум төгрөг байхаар ТЭЗҮ-дээ тусгасан байна. Энэ ордоос жилд 500 мянган тонн хүдэр олборлох хүчин чадалтай байхаар тооцоолжээ. Үүнээс гадна Дорноговь аймгийн нутагт байрлах шохойтын орд газрын ТЭЗҮ-д тусгаснаар нийт хөрөнгө оруулалт 1.13 тэрбум төгрөг байх юм. Ховд аймгийн нутагт байрлах Мянгадын ордын тухайд 2.45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай байхаар ТЭЗҮ-дээ тусгажээ.

Үүнээс гадна Төв аймгийн нутагт байрлах Цагаан дэл орд 0.54 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай, Дорнод аймгийн нутагт байрлах Аралт худаг орд 1.99 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай байхаар ТЭЗҮ-ээ боловсруулжээ.

Нийт долоон төслийн хүрээнд 189 ажлын байр бий болж байгаа гэдгийг Ашигт малтмал, Газрын тосны газрын мэдээллээс харж болохоор байна. Шохойн чулуу нь цементийн үйлдвэрийн гол түүхий эдэд тооцогддог.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 90 орчим хувь нь мега төслүүдэд төвлөрч байна

2018 оны эхний 11 сарын байдлаар Монгол Улсад 1.5 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орсны 90 орчим хувь нь мега төсөлд төвлөрч байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт бүхэлдээ уул уурхайг чиглэсэн байгааг Төв банкны мэдээллээс харж болохоор байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын дүн өнгөрсөн оны мөн үеэс 300 гаруй сая ам.доллаар өсчээ. Хөрөнгө оруулалт “Оюу Толгой” зэрэг томоохон төслүүдэд хэт төвлөрч байгаа учраас цаашид бүх салбарт шууд хөрөнгө оруулалт татах шаардлагатайг харуулж байгаа аж.

2019 онд “Оюу Толгой” төслийн далд уурхайн бүтээн байгуулалтад 1.3 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх төлөвтэй байгаа гэж Сангийн яам мэдээлсэн юм. Мөн дунд хугацаанд Монгол Улсын хөрөнгө, санхүүгийн дансны өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад үнэт цаас, Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд орж ирэх төсвийн дэмжлэг гэж тооцоолжээ.

Дэлхийн банкнаас гадаадын шууд хөрөнгө оруулалтын чиглэлд оновчтой үр дүнд хүрэх хоёр чиглэлийг өгөөд байна. Тухайлбал, байгалийн баялагт түшиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, мөн олборлолтын бус бусад салбаруудад чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах боломжийг тодорхойлох зэрэг юм.

Үндэсний хөгжлийн газраас гадаадын шууд хөрөнгө оруулагчдын дэмжихийн тулд хөрөнгө оруулагчдын нэг цэгийн үйлчилгээний төвийг нэгдүгээр сарын 29-нд нээхээр төлөвлөж ажиллаж байна. Энэ талаар сүүлийн нэг жил бэлтгэж ажиллажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

Зээл авсан ноолуурын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа сэргэжээ

Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ноолуур” хөтөлбөрт оролцогч талууд 2018 онд хийсэн ажил, 2019 оны төлөвлөгөөний талаар 1-р сарын 25-ны өдөр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн суурин төлөөлөгчийн газар зөвлөлдлөө.

Хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ, Хөгжлийн банктай хийсэн гэрээний дагуу тус банкны санхүүжилтээр ноолуурын 20 үйлдвэрт 188.2 тэрбум төгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгийн зориулалтаар олгоод байна. Зээл авсан үйлдвэрүүдийн ноолуур бэлтгэлийн хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад түүхий ноолуур 584.2 тонн (1.3 дахин), самнасан ноолуур 124.9 тонн (1.6 дахин)-оор өссөн байна. Мөн самнах үйлдвэрлэлийн хүчин чадал 33.8 хувь, зэрэх үйлдвэрлэлийнх 28.6 хувь, сүлжих үйлдвэрлэлийнх 42.7 хувиар өсч, 1544 ажлын байр шинээр нэмэгдсэнийг уулзалтын үеэр мэдээлэв.

“Ноолуур” хөтөлбөрийн үйл ажиллагаанд оролцогч талууд болох Засгийн газрын яамд, хэрэгжүүлэгч байгууллага, мэргэжлийн холбоод, боловсролын байгууллага, олон улсын төсөл, хувийн хэвшлүүдийн төлөөллүүд уулзалтын үеэр нэгдсэн ойлголттой болж, цаашид уялдаатай хамтран ажиллах боломж бүрдлээ.

Эх сурвалж: Montsame.mn



Төсөв тэлж байгаа ч мөнгөний бодлого хэрэгжүүлэх орон зай нээлттэй гэж Төв банк үзэж байна

2018 оны IV улирлын эдийн засгийн өсөлтийн гүйцэтгэл хүлээгдэж байгаагаас өндөр гарах төлөв ажиглагдаж байна гэдгийг Төв банк онцолж байна. 2019 оны эдийн засгийн өсөлтийн төлөвийг IV улирлын дүн гарсны дараа шинэчилж танилцуулах боломжтой гэж мэдээлж байсан юм. Мөнгөний бодлогын хүрээнд 2019 онд инфляцийг найм орчим хувьд тогтворжуулах зорилгоо хадгалах бөгөөд 2019 онд төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн зардал нэмэгдэх төлөвтэй байгааг урьдчилан харж 11-р сард мөнгөний бодлогоо чангаруулсан гэдгээ онцоллоо.

Цаашид төсвийн нөлөө хүчтэй байх ч мөнгөний бодлого хэрэгжүүлэх орон зай нээлттэй байгаа гэж үзжээ. Ирэх онд эдийн засгийн өсөлтийг 5-8.5 хувьд байх тооцоог Монголбанк хийсэн юм. Эдийн засгийн өсөлтийг бүрдүүлэх гол хүчин зүйлсээр төсвийн тэлэлт болон энэ онд хийгдсэн хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн парк шинэчлэлийг нэрлэж байна. Импорт өнгөрсөн онд 36 хувиар өссөн байна. Үүний тал орчим хувь нь хөрөнгө оруулалтын импорт байжээ. Мөн банкуудын зээлийн нийлүүлэлт эдийн засгийг дэмжинэ гэж үзсэн байна.

Гадаад талаас Монгол Улсын уул уурхайн экспортын бүтээгдэхүүний үнэ, хэмжээ төдийлөн их хэмжээгээр буухгүй байх төлөвтэй байна гэж тооцоолжээ. Засгийн газар ирэх онд уул уурхайн бүтээгдэхүүнээс төсвийн орлогын 27 хувийг олно гэж төлөвлөсөн байна.

Бизнесийн зээл 2018 онд 17 хувиар өссөн бол иргэдийн зээл үүнээс өндөр буюу хоёр дахин өссөн нь анхаарал татаж байна. Хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогын шийдвэр гарахаас өмнө буюу оны сүүлийн хоёр сард автомашины зээл огцом өссөн гэдгийг Төв банкны судалгаа статистикийн газар онцолж байна. Мөн Монголбанкнаас хийсэн зээлийн төлөвийн түүвэр судалгаагаар сүүлийн гурван сард банкуудын хувьд цалин, тэтгэвэр, болон хэрэглээний зээлийн эрэлт мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэн гэж хариулжээ. Харин ирэх гурван сард банкнууд бизнесийн зээлийн эрэлт нэмэгдэнэ гэж хүлээж байгаа аж.

Төв банкнаас бизнесийн зээлийг дэмжихээр хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогын арга хэмжээ авсан нь хэрэгжиж эхлээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.